

Японы Монгол уран зохиол нийгэмлэгийн дэд захирал, Монгол Улсын Шинжлэх Ухааны Гавьяат зүтгэлтэн, доктор, профессор С.Байгалсайханы нээлтийн үг

Та бүхний энэ өдрийн амрыг эрье.

Японы монгол уран зохиол судлалын нийгэмлэгийн 2022 оны намрын ээлжит хурал өнөөдөр болж байна. 2022 онд Монгол уран зохиолын түүхэнд онцлон тэмдэглэгдэх олон үйл явдал болсон байна. Тухайлбал, ХХ зууны монгол өгүүллэгийн шилдэг төлөөлөгчийн нэг Ж.Лхагвын мэндэлсний 80 жилийн ой болж эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Тангадын Галсан гуайн 90 жилийн ой тохиож мөн эрдэм шинжилгээний хурал, номын баяр хийсэн байна. ХХ зууны Монголын утга зохиолын онолч судлаач, нэрт эрдэмтэн Сономын Лувсанвандангийн мэндэлсний 90 жилийн ой тохиож, мөн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж олон эрдэмтэд илтгэлээ хэлэлцүүлсэн. 2022 оны 11 сарын 10-нд Монгол улсын Соёлын Яамнаас “Утга зохиол судлал, шүүмж, хамтын ажиллагаа, бодлого” форум зохион байгуулж үүнд утга зохиол, ном, хэвлэн нийтлэгчдийн 100 гаруй төлөөлөл оролцож хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.

Удахгүй ХХ зууны Монголын уран зохиолын үндэслэгчийн нэг, нэрт зохиолч Сономбалжирын Буяннэмэхийн мэндэлсний 120 жилийн ойд зориулсан “Буяннэмэх ба эрин цаг” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах гэж байна. Мөн түүнчлэн энэ онд Монгол утга зохиолын олон судалгааны ном бүтээл, толь, дээж бичиг хэвлэгдэн гарсан байна. Үүнд, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Г.Билгүүдэй, доктор Д.Болормаа нарын “Цэнд гүнгийн орчуулсан Монголын нууц товчоон тайлбарт эх” хэмээх 3 боть хэвлэгдэн гарсан. Цэнд гүнгийн орчуулсан “Монголын нууц товчоон”-ы “Юань улсын нууц түүх” хэмээх гар бичмэл эхийг шинэ үсэгт буулган эрдэм шинжилгээний тайлбар үйлдэн бусад эхтэй харгуулж 3 боть ном хэвлүүлээ. Тайлбарт эх номд давхардсан тоогоор 8700 гаруй үгийн тайлбар тодруулбал тайлбарлах үгсийг налуу үсгээр, хуучин монгол бичгээр бичсэн үгийг шинэ үсгээр галиглан бичиж ялгахын зэрэгцээ үгийн утгыг тайлах, зарим нэг буруу бичсэн үгийг зөв болгон засах зэргээр дэлгэрэнгүй ба хураангуй хоёр төрлийн тайлбарыг хадаж оруулсан. Энэ номыг бүтээсэн доктор Г.Билгүүдэй, Д.Болормаа нарт талархал дэвшүүлж байна. Дөнгөж саяхан МУИС-ийн Монгол утга зохиол судлалын тэнхимийн эрдэм багш нар Монгол Улсын Гавьяат багш, доктор, профессор Ч.Билигсайханы эрдэм судлалын бүтээлийг 2 ботиор хэвлэн гаргасан байна. Эл бүтээлийг эрхэлсэн МУИС-ийн Утга зохиолын судлалын эрдэмтэн багш нар талархал илэрхийлье.

Саяхан 2022 оны 11 сарын 22-ны өдөр бид “Монгол утга зохиолын нэвтэрхий толь” 3 бүтээлийн нээлтээ хийсэн. Энэ бүтээлд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Утга зохиол судлал, Аман зохиол судлал, Төвөд судлалын салбарын 30 гаруй эрдэмтэд хамтран бүтээсэн байна. Нийтдээ 190 гаруй хэвлэлийн хуудас, 3300 орчим толгой үгтэй. Монгол эртний уран зохиол, ХХ зууны уран зохиол, Монгол ардын аман зохиол, Өрнөдийн уран зохиол, Дорно дахины уран зохиол, Монгол туургатны уран зохиол, Монголын төвөд хэлт уран зохиол, уран зохиол судлаач эрдэмтэд, тэдний ном бүтээл, утга зохиолын онолын ойлголт, нэр томъёо зэрэг өргөн агуулга багтааснаараа онцлог бүтээл юм.

Өнөөдөр болж байгаа Японы Монгол уран зохиолын нийгэмлэгийн 2022 оны ээлжит хурал маань 2022 оны утга зохиолын үйл явдлыг өндөрлүүлж, дараачийн шинэ судлал, шинэ ажил хэргийн эхлэлийг үндсийг тавьж байна гэж үзэж байна. 2023 онд Олон улсын Монголч эрдэмтдийн ээлжит их хурлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ үеэр Японы монголын уран зохиолын ээлжит хурлаа Улаанбаатар хотноо зохион байгуулж бас болох юм. Та бүхэнд шинэ он, шинэ жилийн мэнд дэвшүүлж, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөхийн ялдамд Японы монгол уран зохиол нийгэмлэгийн 2022 оны намрын ээлжит хурал нээснийг мэдэгдье.